



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 08 сарын 07 өдөр

Дугаар 32

Улаанбаатар хот

Засгийн газар хоорондын комиссын Монголын хэсгийн удирдах бүрэлдэхүүний тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газар, гадаад улсын Засгийн газрын хооронд байгуулсан худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Засгийн газар хоорондын комиссын Монголын хэсгийн удирдах бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор баталсугай.

2. Тухайн улстай хэрэгжүүлж байгаа хамтын ажиллагааны цар хүрээ, зонхилох чиглэл, хуралдаанаар хэлэлцэх асуудалтай уялдуулан хуралдаанд монголын талаас оролцох төлөөлөгчдийн бүрэлдэхүүнийг комиссын Монголын хэсгийн дарга нар тухай бүр томилж байхаар тогтоосугай.

3. Засгийн газар хоорондын комиссын Монголын хэсгийн нарийн бичгийн даргын үүргийг Гадаад харилцааны яамны тухайн улсыг хариуцсан ажилтан гүйцэтгэж байхаар тогтоосугай.

4. Шаардлагатай тохиолдолд Засгийн газар хоорондын тухайн комиссын Монголын хэсгийг холбогдох комиссын Монголын хэсгийн даргатай зөвшилцсөний үндсэн дээр Засгийн газрын бусад гишүүн удирдаж болохыг зөвшөөрсүгэй.

5. Засгийн газар хоорондын комиссын Монголын хэсгийн үйл ажиллагааны зардлыг Гадаад харилцааны сайдын төсвийн багцад тусган санхүүжүүлж байхыг Сангийн сайд Б.Жавхлан, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг нарт үүрэг болгосугай.

6. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Засгийн газар хоорондын комиссуудын Монголын хэсгийн удирдах бүрэлдэхүүний тухай” Засгийн газрын 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 387 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД

Б.БАТЦЭЦЭГ

ШТА1200 002310004 0008449

Засгийн газрын 2024 оны 08 дугаар
сарын 07-ны өдрийн 32 дугаар
тогтоолын хавсралт

ХУДАЛДАА, ЭДИЙН ЗАСАГ, ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНИКИЙН
ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН
КОМИССУУДЫН МОНГОЛЫН ХЭСГИЙН
УДИРДАХ БҮРЭЛДХҮҮН

1.Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Оросын Засгийн газар хоорондын комиссын Монголын хэсэг

Дарга-Монгол Улсын Шадар сайд /бүсчилсэн хөгжил, онцгой байдлын асуудал эрхэлсэн/

Орлогч дарга-Эрчим хүчний сайд

2.Бүс нутаг, хил орчмын хамтын ажиллагааны Монгол, Оросын дэд комиссын Монголын хэсэг

Дарга-Монгол Улсын сайд, Бoomтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга

3.Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Хятадын Засгийн газар хоорондын комиссын Монголын хэсэг

Дарга-Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд

Орлогч дарга-Зам, тээврийн сайд

4.Эрдэс баялаг, эрчим хүч, дэд бүтцийн хамтын ажиллагааны Монгол, Хятадын хамтарсан зөвлөлийн Монголын хэсэг

Дарга-Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд

5.Монгол Улсын Засгийн газар, Евразийн эдийн засгийн комисс хоорондын хамтын ажиллагааны ажлын хэсгийн Монголын хэсэг

Дарга-Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд

6.Монгол Улс, АНУ хоорондын Худалдаа, хөрөнгө оруулалтын хамтарсан хорооны Монголын хэсэг

Дарга-Монгол Улсын Шадар сайд /гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн/

7.Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Беларусийн Засгийн газар хоорондын комиссын . Монголын хэсэг

Дарга-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд

8.Монгол, Британийн дугуй ширээний уулзалтын Монголын хэсэг

Дарга-Монгол Улсын Шадар сайд /бүсчилсэн хөгжил, онцгой байдлын асуудал эрхэлсэн/

9.Худалдаа, эдийн засаг, соёл, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Вьетнамын Засгийн газар хоорондын комиссын Монголын хэсэг

Дарга-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд

10.Ашигт малтмал, аж үйлдвэр, технологийн салбарт хамтран ажиллах тухай Монгол, Германы Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий ажлын хэсгийн Монголын хэсэг

Дарга-Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд

11.Монгол Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Засгийн газар хоорондын Хөгжлийн бодлогын хамтын ажиллагааны хэлэлцээний Монголын хэсэг

Дарга-Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга

12.Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техник, соёлын хамтын ажиллагааны Монгол, Казахстаны Засгийн газар хоорондын комиссын Монголын хэсэг

Дарга-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд

13.Монгол, Катарын Засгийн газар хоорондын комиссын Монголын хэсэг

Дарга-Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд

14.Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техник, соёлын хамтын ажиллагааны Монгол, Киргизийн Засгийн газар хоорондын комиссын Монголын хэсэг

Дарга-Монгол Улсын Шадар сайд /бүсчилсэн хөгжил, онцгой байдлын асуудал эрхэлсэн/

15.Монгол, Кувейтийн Засгийн газар хоорондын комиссын Монголын хэсэг

Дарга-Сангийн сайд

16.Эдийн засаг, техникийн хамтын ажиллагааны Монгол, Италийн .
Засгийн газар хоорондын холимог комиссын Монголын хэсэг

Дарга-Гадаад харилцааны сайд

17.Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн салбарт хамтран ажиллах Монгол, Лаосын Засгийн газар хоорондын комиссын Монголын хэсэг

Дарга-Зам, тээврийн сайд

18.Эдийн засгийн хамтын ажиллагааны Монгол, Польшийн Засгийн газар хоорондын хамтарсан комиссын Монголын хэсэг

Дарга-Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд

19.Монгол Улс, БНСУ-ын Засгийн газар хоорондын хамтарсан хорооны Монголын хэсэг

Дарга-Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга

20.Монгол, Тайландын Засгийн газар хоорондын зөвлөлийн Монголын хэсэг

Дарга-Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд

21.Эдийн засаг, худалдааны Монгол, Туркийн Засгийн газар хоорондын хамтарсан хорооны Монголын хэсэг

Дарга-Батлан хамгаалахын сайд

Дэд дарга-Монгол Улсын сайд, 20 минутын хот Үндэсний хорооны дарга

22.Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Узбекистаны Засгийн газар хоорондын комиссын Монголын хэсэг

Дарга-Монгол Улсын Шадар сайд /бүсчилсэн хөгжил, онцгой байдлын асуудал эрхэлсэн/

Дэд дарга-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд

23.Эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Финландын Засгийн газар хоорондын комиссын Монголын хэсэг

Дарга-Боловсролын сайд

24.Хамтын ажиллагааны Монгол, Францын Засгийн газар хоорондын ажлын хэсгийн Монголын хэсэг

Дарга-Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга

25.Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Чехийн Засгийн газар хоорондын комиссын Монголын хэсэг

Дарга-Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд

26.Монгол, Эмиратын Засгийн газар хоорондын Эдийн засгийн хамтарсан хорооны Монголын хэсэг

Дарга-Сангийн сайд

27.Монгол, Энэтхэгийн Засгийн газар хоорондын хамтарсан хорооны Монголын хэсэг

Дарга-Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга

Дэд дарга-Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд

28.Монгол, Японы төр, хувийн хэвшлийн зөвлөлдөх уулзалтын Монголын хэсэг

Дарга-Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд.

